



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/38/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 7033-3019 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	---

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**АРХАНГАЙ АЙМАГ**  
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.09.22 № 154

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 239 дүгээр тогтоолоор бүрэн тэтгэврийн доод хэмжээг 50.0 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 40.0 мянга, дундаж тэтгэврийн хэмжээ 162.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн бөгөөд Архангай аймгийн хэмжээнд сард 15,572 тэтгэвэр авагчийн тэтгэврийн зардал 3.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэл 550.0 мянган төгрөг болж нэмэгдсэн.

### Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 107, 489, 491 дүгээр тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоол, Архангай аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжийн дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн сан 26.8 хувиар нэмэгдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас **92.7** хувиар үнэлжээ.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,654,125.8	10,148,199.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,735,570.6	8,658,671.8
33	АВЛАГА	1,916,690.2	1,487,670.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,864.9	1,858.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	797,631.4	772,085.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	797,631.4	772,085.6
39200	Биет хөрөнгө	782,451.4	756,905.6
39300	Биет бус хөрөнгө	15,180	15,180.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,451,757.1	10,920,285.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	145,240.8	473,439.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	145,240.8	473439.1
41300	Өглөг	1,095.2	19,768.1
41400	Урьдчилж орсон орлого	144,145.6	453,671.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,306,516.4	10,446,846.3
51	Засгийн газрын хувь оролцоо	10,306,516.4	10,446,846.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,570.9	224,570.9
51200	Хуримтлагдсан үр дүн	10,081,331.4	10,221,661.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	614.2	614.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,451,757.1	10,920,285.4

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	106,126,378.2	117,767,694.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	26,558,477.3	34,565,048.4
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	26,558,477.3	34,565,048.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	719,183.4	338,750.5
120	Нийтлэг татварын бус орлого	719,183.4	338,750.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,848,717.5	82,863,895.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	104,535,134.3	117,627,364.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,535,134.3	117,627,364.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	697,845.2	1,153,292.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,129.2	897,842.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,684.4	111,689.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,463.7	32,518.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,903.2	40,153.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,155.4	5,076.1
2107	Томилолт, зочны зардал	2,976.4	9,244.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,223.1	15,426.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,309.9	41,341.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,837,289.1	116,474,072.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,591,243.9	140,329.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,591,243.9	140,329.9

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	106,250,573.0	118,545,694.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	26,551,189.7	34,672,035.4
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	26,551,189.7	34,672,035.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	602,700.6	597,799.9
120	Нийтлэг татварын бус орлого	602,700.6	597,799.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,096,682.7	83,275,859.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,581,663.4	117,622,593.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,581,663.4	117,622,593.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,972.4	1,108,295.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,129.2	897,842.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,684.4	111,689.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,463.7	32,518.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,903.2	37,507.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,155.4	5,076.1
2107	Томилолт, зочны зардал	2,976.4	9,244.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,776.5	14,269.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,883.6	147.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,909,691.0	116,514,297.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,668,909.6	923,101.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,668,909.6	923,101.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,066,661	7,735,570.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,735,570.6	8,658,671.8

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,716,744.4	8,8716,744.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,472.0	-1,472.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,715,272.5	8,715,272.5
9	Тайлант үеийн үр дүн	1,591,243.9	1,591,243.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,306,516.4	10,306,516.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,306,516.4	10,306,516.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,306,516.4	10,306,516.4
19	Тайлант үеийн үр дүн	140,329.9	140,329.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,446,846.3	10,446,846.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ Мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,955,369.9	108,587,783.2	3,367,586.7	97.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,955,369.9	108,587,783.2	3,367,586.7	97.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,219,244.8	1,108,295.8	110,949.0	90.9%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	985,123.3	897,842.8	87,280.5	91.1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,077.0	111,689.4	11,387.6	90.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,280.1	32,518.0	762.1	97.7%
2104	Хангамж, бараа материалын зардал	41,402.0	37,507.0	3,895.0	90.6%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,087.4	5,076.1	11.3	99.8%
2107	Томилолт, зочны зардал	11,575.5	9,244.6	2,330.9	79.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,799.5	14,268.8	3,530.7	80.2%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.0	147.5	1752.5	7.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,736,125.1	107,479,487.4	3,256,637.7	97.1%
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,736,125.1	107,479,487.4	3,256,637.7	97.1%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,955,369.9	39,507,886.2	72,447,483.7	35.3%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,285,101.5	10,285,101.5	0.0	100%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	101,670,268.4	28,704,036.8	72,966.2	28.2%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		518,747.9	518,747.9	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,735,570.6	7,735,570.6	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,658,671.8	8,658,671.8	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	44	44	0	100%

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй.

Залруулагдаагүй нийт 32,599.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 32,599.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 32,599.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 559,776.8 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Тус байгууллага нь НДЕГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалын 6-р хавсралтаар Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн орон тоо, албан хаагчдын жагсаалт, Архангай аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2018.03.19-ний өдрийн 6/14 дүгээр тушаалаар сайн дурын даатгалын байцаагч-1, сангийн нягтлан бодогч-1 байхаар бүтэц орон тоог баталсан байхад тайлант хугацаанд дээрх орон тоонд нэмж 5 гэрээт ажилтныг сэлгүүлэн ажиллуулж 31,674.6 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" үүнд 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, зөрчлийг таслан зогсоож, батлагдсан орон тоог нэмж, чиг үүргийг давхардуулан ажиллахгүй байхад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлэх*

5.2.3. Цалингийн сангаас албан хаагчид 924.4 мянган төгрөгийн тэтгэмж урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 190 дүгээр тушаалын 210104 "Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу ажлын үр дүнг сар, улирал, жилээр үнэлэн олгох мөнгөн урамшуулал ...гэх мэт зардлыг энд бүртгэнэ. Урамшуулал нь ажлын үзүүлэлтээр тооцож хагас бүтэн жилээр цалингийн тодорхой хувиар болон үнэмлэхүй хэмжээгээр тооцон олгох хэлбэртэй байж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага	Албан тушаалтны тоо		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн сангаас дэмжлэг олгосонтой холбоотой	1	924.4	-	-	1	924.4	-	-	-	-	-	-
Шинэ орон тоотой холбоотой	1	31,674.6	-	-	1	31,674.6	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН	2	32,599.0	-	-	2	32,599.0	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-